

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5, 24, 36, 52,521, 57 дугаар зүйлд дор дурдсан агуулгатайхэсэг, заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 24 дэх заалт:

“5.1.24. “өөрийн хэрэгцээнд худалдан авахбараа, ажил, үйлчилгээ” гэж зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээг;”

2/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 25 дэх заалт:

“5.1.25. “Цахим худалдан авалт” гэж мэдээллийн технологи, цахим системийгашиглан зохион байгуулах худалдан авах ажиллагааг”

3/ 24 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

“24.6. Нээлттэй тендер шалгаруулалт амжилтгүй болж дахин нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулахтохиолдолд тендер хүлээн авах эцсийн хугацааг 20 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.”

4/ 36 дугаар зүйлийн 18 дахь хэсэг:

“36.18. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтыг явуулахтай холбогдсон энэ бүлгээр зохицуулаагүй харилцааг энэ хуулийн 2 дугаар бүлэг, 34 дүгээр зүйлээр зохицуулна.”

5/ 521 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“521.3. Энэ хуулийн 521.1-д заасан эрх бүхий улсын байцаагчийн эрхийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.”

6/ 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 17 дахь заалт:

“52.1.17. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хөтлөх журмыг батлан, мөрдүүлэх.”

7/ 57 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 24 дэх заалт:

“57.1.24. энэ хуулийн 48.3, 48.4-т заасныг зөрчсөн бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;”

8/ 57 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 25 дахь заалт:

“57.1.25. энэ хуулийн 46.1.9-т заасныг зөрчсөн бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;”

9/ 57 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 26 дахь заалт:

“57.1.26. энэ хуулийн 55.1-д заасны дагуу гаргасан гомдлыг хянан үзэхэд шаардлагатай материалыг тогтоосон хугацаанд хүргүүлээгүй захиалагчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;”

2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийн “тендерийн” гэсний дараа “харьцуулах” гэж, 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалтын “30.4.2” гэсний дараа “36.17-д” гэж, 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь заалтын “хамгийн бага” гэсний дараа “харьцуулах” гэж, 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалтын “тухайн орон нутагт” гэсний өмнө “энэ хуулийн 45.5-д заасан жагсаалтаар батлагдсанаас бусад” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “100,000.001” гэснийг “1,000,000,001” гэж, 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “10,000,000.001” гэснийг “10,000,000,001” гэж, 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “аль нэгийг” гэснийг “аль тохирохыг” гэж, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс” гэснийг “батлагдсан төсөвт өртгөөс” гэж, 36 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “саналын урилга” гэснийг “тендерийн урилга” гэж, 36 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн “санал ирүүлэх” гэснийг “тендер ирүүлэх” гэж, мөн хэсгийн “30-аас” гэснийг “20-иос” гэж, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “Засаг даргын Тамгын газар” гэснийг “Засаг дарга” гэж, 45 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тухайн шатны Засаг даргын Тамгын газар” гэснийг “тухайн шатны Засаг дарга” гэж, 45 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “5 өдрийн дотор” гэснийг “10 өдрийн дотор” гэж, мөн хэсгийн “мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлэх улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний жагсаалтыг” гэснийг “мэргэжлийн байгууллагын болон аймаг, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны жагсаалтыг” гэж, 45 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Засаг даргын Тамгын газар нь” гэснийг “Засаг дарга нь” гэж, мөн хэсгийн “сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт” гэснийг “сум, дүүргийн Засаг даргад” гэж, 46 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “төсвийн ерөнхий менежер” гэснийг “төсвийн шууд захирагч, аймаг, нийслэл, дүүргийн захиалагчийг энэ хуулийн 53.2-т заасан нэгж” гэж, 48 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн “улсын төсөв батлагдсанаас хойш” гэснийг “энэ хуулийн 45.5-д заасан жагсаалт батлагдсанаас хойш” гэж, 51 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хөндөхгүй” гэснийг “хязгаарлахгүй” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус” гэснийг, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “хэлбэр маяг” гэснийг, 28 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5 дахь заалтын “эмнэлгийн тоног төхөөрөмж” гэснийг, 45 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “энэ хуулийн 45.2, 45.3-т зааснаас бусад болон” гэснийг, 47 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын “эсхүл” гэснийг тус тусхассугай.

5 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 36 дугаар зүйлийн 4, 5, 6, 7, 8, 17 дахь хэсэг, 53 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3, 4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2013 оны сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.